

“ЭРДЭНЭС СОЛЮШИНС” ХК

2026 оны 04 дүгээр сарын 25-ний өдөр

№ ХТ 01/2026

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 25-ний өдрийн 12.00 цагаас 12.30 цагийн хооронд <https://meet.google.com/ydt-kwea-ion> програмыг ашиглан хуралдав.

Хурал зохион байгуулах комисс болон Тооллогын комиссоос хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцохоор ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэж, 122,036,314/нэг зуун хорин хоёр сая гучин зургаан мянга гурван зуун арван дөрвөн / ширхэг буюу 69.50 /жаран ес аравны таван/ хувийг эзэмшигчид оролцож байгаа талаар танилцуулж, хурлын ирц компанийн дүрэм болон хуулийн дагуу бүрдсэн тул хурал хүчин төгөлдөрт болсон тухай Тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд Субашид тек ХХК-ийг төлөөлж Ц.Хүдэрмөнх итгэмжлэлээр хуралд оролцов. Компанийн зүгээс цахим хурлыг бичлэг хийж хадгалав.

Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэрийн 2 дугаар хавсралтад заасан “Хурлын хөтөлбөр, дэг”-ийн дагуу хэлэлцэх асуудлын эхэнд хувьцаа эзэмшигчдээс хурлын даргыг сонгов.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэв.Үүнд:

1. Компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайланд аудит хийлгэсэн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж батлах тухай;
3. Компанийн шинэчилсэн дүрэм батлах тухай.
4. Шонхор дронс ХХК нэмж 1(нэг) бүр нь нэг төгрөгийн үнэтэй 180'000'000 (нэг зуун наян сая) төгрөгийн нэмж хувьцаа гаргах тухай.
5. Нэмж гаргасан хувьцааг компанид ноогдох өөрийн эзэмшиж буй энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэргүүн ээлжид худалдан авах эрхээ эдлэх эсэх тухай.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Т.Золбоо хувьцаа эзэмшигчдийн хурлын хөтөлбөрийн дагуу хурлыг нээж хурлаар компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланг танилцсан учир санал хэлэх хувьцаа эзэмшигч байгаа эсэх талаар санал асуув.

1,2-р хэлэлцэх асуудлаар:

Хурлын дарга Ц. Золбоо: Хөтөлбөрийн дагуу хэлэлцэж буй асуудлуудтай холбоотой санал, асуулга явуулья.

Хувьцаа эзэмшигчидээс ямар нэгэн санал, асуулга явагдсангүй тул санал хэлэлцэж байгаа асуудлаар санал хураалт явуулья. Хэлэлцэх асуудал тус бүрийг цахимаар гар өргөж санал аа өгнө үү. Тооллогын комисс үүнийг бүртгэж авна уу.

Тооллогын комиссын дарга Г. Төгөлдөр: Тооллогын комиссын тогтоолыг танилцуулав. Хуралд оролцож буй санал өгсөн саналыг тоолоход хүчингүй болсон, түдгэлзсэн, эсрэг санал гарсангүй. Санал дараах байдлтай байна.

Үүнд:

№	Хэлэлцсэн асуудлууд	Ээлжит хуралд оролцож буй санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн								Нийт	
		Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн		Хүчингүй болсон			
		ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь

		ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь
1	Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланг батлах тухай	122,036,314	100%	-	-	-	-	-	-	122,036,314	100%
2	Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг батлах тухай	122,036,314	100%	-	-	-	-	-	-	122,036,314	100%
3	Компанийн шинэчилсэн дүрэм батлах тухай	122,036,314	100%							122,036,314	100%
4	Шонхор дронс ХХК нэмж 1(нэг) бүр нь нэг төгрөгийн үнэтэй 180'000'000 (нэг зуун наян сая) төгрөгийн нэмж хувьцаа гаргах тухай	122,036,314	100%							122,036,314	100%
5	Нэмж гаргасан хувьцааг компанид ноогдох өөрийн эзэмшиж буй энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэргүүн ээлжид худалдан авах эрхээс татгалзах тухай	122,036,314	100%							122,036,314	100%

Хувьцаа эзэмшигчид 100% санал нэгтгэйгээр зөвшөөрч эсрэг болон түдгэлзсэн саналгүй тул Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарч буй шийдвэрийг уншиж танилцуулав.

“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК-НЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН 2026 ОНЫ 04-Р САРЫН 25-НИЙ ӨДРИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ДАРААХ АСУУДЛУУДЫГ ШИЙДВЭРЛЭВ. ҮҮНД:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж батлав;
2. Компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайланд аудит хийлгэсэн дүгнэлтийг хэлэлцэж батлав;
3. Компанийн шинэчилсэн дүрэм батлав;
4. Шонхор дронс ХХК нэмж 1(нэг) бүр нь нэг төгрөгийн үнэтэй 180'000'000 (нэг зуун наян сая) төгрөгийн нэмж хувьцаа гаргахыг дэмжиж батлав;
5. Нэмж гаргасан хувьцааг компанид ноогдох өөрийн эзэмшиж буй энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэргүүн ээлжид худалдан авах эрхээс татгалзаж, батлав.

ХУРЛЫН ДАРГА



/ Т.ЗОЛБОО/